

ЦХӨЛҮҮДҮҮД ТҮҮХНЭДҮҮЛСНЭЙН НӨХЧИЙН НҮҮДЛҮҮД НҮҮДЛҮҮЛГЭН

Монгол: Бүс нутгийн хүн амын хэтийн төлөв байдал

Хүснэгт 5

	1991	1992	1993	1994	1995
Ц. Болормаа ХАЗССТ, багш	11 660 320	11 660 320	11 660 320	11 660 320	11 660 320
Ун. М. Сүрье ДМБ "Онгөрсөн үеийн хандлага"	11 660 320	11 660 320	11 660 320	11 660 320	11 660 320
Ганзориг	11 660 320	11 660 320	11 660 320	11 660 320	11 660 320

1921 оны хувьсгалын дараа үндэстэн мөхөх аюулаас аврагдсан хэдий ч 1950-иад оны дунд үеийг хүртэл хүн амын өсөлт тун доогуур түвшинд удаанаар хадгалагдаж байлаа. 1918-аас 1950 оны хооронд Монголын хүн ам 648,1-ээс 772,4 мянга болж, 124 мянгаар нэмэгдсэн ба хүн амын өсөлтийн жилийн дундаж хурд дөнгөж 0,6 хувь байв. Энэ үед нийгэм эдийн засгийн хөгжлийн буурай түвшнээс дагаад эрүүлийг хамгаалах системийн байдал тун дорой байснаас хүн амын дунд өвчлөл өндөр, нас баралтын түвшин харьцангуй их байлаа. Мөн түүнчлэн 1930-аад оны улс төрийн хэлмэгдүүлэлт, 1939, 1945 онуудын дайн самуунууд зэрэг нийгэм улс төрийн тогтвортгүй нөхцөлүүд нь шууд болон шууд бус замаар төрөлтийн түвшинд сөргөөр нөлөөлж, хүн амын өсөлтийг хангахад ихээхэн саад учруудж байсан томоохон хүчин зүйлүүд болсон.

Дэлхийн 2-р дайны дараа олон хөгжиж буй улсууд тусгаар тогтолцоо зарлан, нийгэм дэйн засгийн байдал нь харьцангуй тогтвортгиж ирсэн нь хүн амын өсөлтөд ч нэгэн адил нөлөөлж, төрөлтийн түвшин огцом нэмэгдсэнээс гадна, хөгжингүй улс орнуудаас анагаах ухааны шинэ ололтууд, эрүүлийг хамгаалахын боловсон хүчин болон материаллаг туслалцааг шууд авах бололцоо нээгдсэн зэрэг нь эдгээр орнуудын хүн амын ердийн өсөлтийн хурд богино хугацаанд нь нэмэгдэх нөхцөлийг бүрдүүлж өгсөн билээ.

Хүснэгт 1. Хүн амын тоо, өсөлтийн хурд, 1918–1996 /мян.
хүн, оны эцэст/

Он	Хүн амын тоо	Өсөлтийн хувь
1918	648.1	—
1930	727.4	1.01
1940	743.8	0.15
1950	772.4	0.38
1960	968.1	2.28
1970	1265.4	2.78
1980	1682.0	2.89
1990	2149.3	2.48
1996	2353.3	1.58

Мэдээллийн эх үүсвэр: "Монгол улсын хүн ам", УСГ, 1996

Энэхүү нийтлэг хандлага Монгол ч гэсэн ажиглагдсан юм. 1950-иад оны дунд үеэс улс төрийн тогтвортгилтоо даган нийгэм эдийн засгийн өсөлтийн хурдац нэмэгдэх болсон нь нийгмийн бүх салбарт зерэг нөлөө үзүүлсэн билээ. Энэ нь цаашид хүн ам эрчимтэй өсөх сайхан хөрөс болжээ. 1960-аад

оноос 1980-аад оныг хүртэл Монголын хүн амын өсөлтийн хурд дээшилсээр бараг 3 хувь болсон нь дэлхийн дунджаас (1.9 хувь) нэлзээд дээгүүр орох үзүүлэлт байлаа.

1990-ээд оны социалист системийн орнуудыг хамарсан улс төр, нийгэм эдийн засгийн тогтолцооны бүрэн өөрчлөлт нь Монголд нэгэн адил явагдсан бөгөөд зах зээлийн эдийн засагт шилжин, бараа бүтээгдэхүүний үнийн огцом өсөлт, инфляци, ажилгүйдэл зэрэг үзэгдэл нь улс оронд эдийн засгийн гүнзгий хямрал үүсгэн, өрх, хүн амын амьжиргаа дорийтох үндэс болсон. Үүнийг дагаад 1986–1990 онд хүн амын өсөлтийн хурд 2.5 хувь байснаа 1990–1994 оны үед өсөлтийн хурд эрс бууран 1.5 хувьд хүрсэн ба харин сүүлийн 2 жилд төрөлтийн түвшин бага зэрэг нэмэгдэж, өсөлтийн хурдаа 1.6-д тогтворжих хандлага ажиглагдаж байна.

1996 онд хүн амын өсөлтийн хурд 1.5 хувь байсан ба үүнийг аймгийн ялгавартай байдлаар авч үзэхэд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотууд, Баян-Өлгий, Хэнтий, Ховд аймгуудад улсын дунджаас өндөр байна. Мөн үед эдгээр хотуудад 1000 хүнд ногдох төрөлт улсын дунджаас 2–5 пунктээр доогуур байгаагаас харахад хотуудын хүн амын өсөлт нь ердийн хөдөлгөөнөөр бус харин шилжин ирэгсдийн хэмжээнээс шалтгаалан бусад бүсээс харьцангуй өндөр гарсан нь тодорхой байна.

Ирээдүйн төлов байдал

Шинэ эрин зуунд хөгжлийн ямар түвшинд хүрэх нь тухайн улс орны нийгэм эдийн засгийн бодлоготой салшгүй холбоотой ба нийгэм эдийн засгийн хөгжлийн төлөвлөлтөд хүн амын ирээдүйн тоо хэмжээ маш чухал үүргийг гүйцэтгэгч болдог. Иймд хүн амын өсөлтийн чиг хандлагыг тодорхойлох зайлшгүй шаардлага гарч байгаа бөгөөд ийм ч учраас төрөлт, нас барагтын цаашдын хандлагыг, зарим тохиолдолд шилжих хөдөлгөөнийг анхааралтай судлах нь хүн ам зүйчдийн хойшлуулашгүй чухал ажлын нэг болж байна.

Монгол улсын хүн амын хэтийн тооцоог 1989 оны хүн амын тооллогын мэдээн дээр үндэслэн, аймаг, хотоор, 1989–2024 он хүртэлх (нийт 35 жилийн) хэтийн төлөв байдлын талаарх тооцоог хийлгээ. Тооцооны эхэн үед тус улсын хүн ам 2.0 сая гаруй хүн амтай байсан бол XX зууны эцэс гэхэд 2.7 саяас ихгүй байхаар төлөвлөгдж байна. Хэтийн тооцооны төгсгөлийн үед буюу 2019–2024 он гэхэд Монгол улсын хүн ам 4.1–4.3 сая болох юм. Хүн амын тооны өсөлт ирэх зууны эхэн гэхэд мөн л үргэлжлэн өсөх хандлагатай байна. Монголын хүн ам 1918 онд 647.5 мян. байсан бол 1989 оны тооллогоор 2044.0 мянгад хүрч 1918 оныхоос 3.2 дахин, 1960 оныхоос 2.2 дахин өсчээ. 1996 оны байдлаар 2313.0 хүн байгаа ба энэ зууны эцэст буюу 1999 онд 2666.5 мянга, 2019 он гэхэд 4061.6 мянгад хүрч 1996 оныхоос 1750.0 мянга орчим хүнээр нэмэгдэх төлөвтэй байна. Хүн амын тоо 1918 оныхоос 6.3 дахин, 1989 оныхоос 2 дахин, 1996 оныхоос 1.7 дахин өсөх хандлагатай байгаа юм. Хүснэгт 2-д хүн амын ирээдүйн төлөв байдлын талаарх тоон мэдээллийг үзүүллээ.

Монгол улсын хүн ам 1960-аад оны дунд үед 1 сая, 1989 онд 2 сая хүрч байсан бол ирэх зууны эхний арван жилд тодруулбал бүр эхний таван

жилийн дотор 3 саяд хүрч, ирэх зууны эхний 25 жилийн дотор 4 саяд хүрч тогтвортжилт хүртлээ өсөх хандлага ажиглагдаж байгаа юм.

Монголын хүн ам нь өсч байгаа хүн ам бөгөөд цаашдын 30–50 жилийн туршид үргэлжлэн өсөх боломжтой гэдэг нь харагдаж байна. Нас барагтын харьцангуй удаан боловч буурч байгаа түвшин болон шилжих хөдөлгөөнийн нөлөөлөл бага ийм нөхцөлд хүн амын өсөлтөд нөлөөлөгч гол хүчин зүйл нь төрөлтийн түвшин байх болно.

Хүснэгт 2. Хүн амын тоо, Монгол, 1918–2024 он

Он	Хүн амын тоо (мян. хүн)
1918	648,1
1935	1122,2
1944	1250,0
1956	1450,0
1963	1600,0
1969	1700,0
байсан темоо он	1750,0
1979	1850,0
1989	1950,0
1996	2050,0
Дэлхийн тогтолцоо зар шанцо Чын Ондоо жисте гийн зама тухайнхан	2150,0
1999	2250,0
2004	2350,0
2009	2450,0
2014	2550,0
2019	2650,0
2024	2750,0

— Бүртгэгдсэн

■ — Тооцсон

Хэдийгээр нэг эмэгтэйд ногдох төрөлтийн тоо сүүлийн жилүүдэд болон ирээдүйд буурч байгаа боловч төрөлт өндөр байсан 1960–аад оны дараагаар төрсөн олон тооны охид хүүхэд төрүүлэх насандaa хэдийнээ хүрч, жилд шинээр төрөх хүүхдийн тоо олон байх нөхцөлийг бүрдүүлж байна. Ийм тохиолдолд нэг эмэгтэй бүхий л амьдралынхаа туршид ганц тооны хүүхэд төрүүлж байсан ч дараачийн жилүүдэд хүн ам өссөөр байх болно. 21-р зууны эхний 20 жилийн төгсгөл үе гэхэд дэлхийн ихэнх орнуудын нэгэн адил хүн амын төрөлт, нас барагтын түвшин хоёулаа бага байх нөхцөл бүрдэх ба өөрөөр хэлбэл хүн ам зүйн шилжилтийн хамгийн сүүлчийн шатанд дөхөж очих буюу төрөлтийн тоо үндсэндээ хүн амын өөрсдийгөө нөхөх түвшинд дөхөж очно гэж төсөөлж байгаа бөгөөд ямар ч л байсан хүн амын тоо тогтвортжих хүртлээ өсөх нь дамжигтгүй ба хүн амын тооны өсөлтийн тогтвортжилт 2040 он түүнээс хойших үед байхаар төсөөлөгдж байгаа бөгөөд бидний энэ тооцоололд гадны зарим нэг хүчин зүйл буюу цөмийн дайн эсвэл ямар нэг аюулыг огт тооцоолохгүй байгаа билээ.

Хүн амын өсөлтөд тухайн улс орны аймаг, бүсийн хүн амын өсөлт өөрчлөлт ихээхэн нөлөөлөлийг үзүүлдэг. Хүснэгт 3-д аймаг, хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жингийн талаарх мэдээллийг харуулав.

1999 оны нийт хүн амд Баян-Өлгий /4,9%/, Өвөрхангай /4,8%/, Төв /5,0%/, Хөвсгөл /5,0%/ аймгууд болон нийслэл Улаанбаатар хот /26,0%/-ын хүн ам бусад аймгуудаасаа нэлээд өндөр хувийг эзэлж байгаа бол энэ үзүүлэлт 2009–2024 оны үед төв болон баруун бүсийн аймгууд дээр нэлээд төвлөрөх хандлагатай байна.

Хүснэгт 3. Аймаг, хотын хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин, Монгол, аймаг, хотоор, хувиар, 1999–2024 он

Аймаг, хот	1999	2004	2009	2014	2019	2024
Бүгд	100,0	100,0	100,0	100,0	100,0	100,0
Архангай	4,3	4,4	4,5	4,6	4,6	4,6
Баян-Өлгий	4,9	5,0	4,8	4,4	4,5	4,5
Баянхонгор	3,8	3,9	4,0	4,1	4,2	4,2
Булган	2,6	2,7	2,7	2,7	2,7	2,6
Говь-Алтай	3,0	3,1	3,1	3,1	3,1	3,1
Дорноговь	2,7	2,7	2,6	2,6	2,7	2,7
Дорнод	3,6	3,7	3,7	3,6	3,6	3,5
Дундговь	2,4	2,4	2,5	2,6	2,6	2,6
Завхан	4,2	4,3	4,4	4,4	4,3	4,3
Өвөрхангай	4,8	4,9	5,0	5,2	5,3	5,3
Өмнөговь	2,0	2,0	2,0	2,0	1,9	1,9
Сүхбаатар	2,5	2,6	2,7	2,8	2,8	2,8
Сэлэнгэ	4,3	4,3	4,3	4,3	4,3	4,3
Төв	5,0	5,0	5,1	5,1	5,0	5,1
Увс	4,2	4,3	4,3	4,4	4,4	4,4
Ховд	4,1	4,3	4,4	4,5	4,6	4,7
Хөвсгөл	5,0	5,0	5,1	5,2	5,2	5,3
Хэнтий	3,6	3,5	3,5	3,5	3,5	3,5
Дархан-Уул	3,9	3,7	3,7	3,7	3,5	3,5
Улаанбаатар	26,0	25,0	24,3	24,0	23,8	23,7
Орхон	2,8	2,7	2,8	2,9	2,9	2,9
Говьсүмбэр	0,5	0,5	0,4	0,4	0,4	0,4

Харин нийслэл Улаанбаатар хотын хүн амын улсын нийт хүн амд эзлэх хувийн жин 26,0–23,7% болж буурах хандлага ажиглагдаж байгаа юм. Өмнөговь /2,0%/, Говьсүмбэр /0,5%/, Сүхбаатар /2,7%/, Дундговь /2,4%/ зэрэг говийн болон тал хээрийн бүсийн аймгуудын хүн амын нийт хүн амд эзлэх хувийн жин харьцангуй бага байгаа бөгөөд энэ үзүүлэлт хэтийн тооцооны төгсгөлийн үед мөн л бага хэвээр байх төлөвтэй.

Хүснэгт 4-д нийт хүн амд аймаг хотын хүн амын эзлэх хувийн жин хамгийн их буюу хамгийн бага байх таван аймаг, хотыг хэтийн тооцооны үе тус бүрээр үзүүллээ. Дээрх хүснэгтээс харахад ирээдүйн хүн амын өсөлтөд баруун болон төвийн бүсийн аймгууд зонхилох үүргийг гүйцэтгэх ба учир нь тэдгээр бүс нутагт хүн амын төрөлтийн түвшин харьцангуй өндөр ба бүр улсын дунджаас ихэнх тохиолдолд өндөр байдагтай холбоотой юм. Хүн амын өсөлтийн байдлыг бүс нутгийн ялгавартай байдлаар үзүүлэхийн тулд аймаг, хотуудаа байршил, газар нутгийн онцлогоос нь шалтгаалан хэд хэдэн бүс болгон хуваалаа.

**Хүснэгт 4. Нийт хүн амд аймаг, хотын хүн амын эзлэх хувийн жин
хамгийн их буюу хамгийн бага 5 аймаг, хот, Монгол, 1999–2024 он**

Он	Хамгийн их	%	Хамгийн бага	%
1999	1. Улаанбаатар	26,0	1. Говьсүмбэр	0,5
	2. Төв	5,0	2. Өмнөговь	2,0
	3. Хөвсгэл	5,0	3. Дундговь	2,4
	4. Баян-Өлгий	4,9	4. Сүхбаатар	2,5
	5. Өвөрхангай	4,8	5. Булган	2,6
2004	1. Улаанбаатар	25,0	1. Говьсүмбэр	0,5
	2. Төв	5,0	2. Өмнөговь	2,0
	3. Хөвсгэл	5,0	3. Дундговь	2,4
	4. Баян-Өлгий	5,0	4. Сүхбаатар	2,6
	5. Өвөрхангай	4,9	5. Дорноговь	2,7
2009	1. Улаанбаатар	24,3	1. Говьсүмбэр	0,4
	2. Төв	5,1	2. Өмнөговь	2,0
	3. Хөвсгэл	5,1	3. Дундговь	2,5
	4. Өвөрхангай	5,0	4. Дорноговь	2,6
	5. Баян-Өлгий	4,8	5. Сүхбаатар	2,7
2014	1. Улаанбаатар	24,0	1. Говьсүмбэр	0,4
	2. Өвөрхангай	5,2	2. Өмнөговь	2,0
	3. Хөвсгэл	5,2	3. Дорноговь	2,6
	4. Төв	5,1	4. Дундговь	2,6
	5. Архангай	4,6	5. Булган	2,7
2019	1. Улаанбаатар	23,8	1. Говьсүмбэр	0,4
	2. Өвөрхангай	5,3	2. Өмнөговь	1,9
	3. Хөвсгэл	5,2	3. Дундговь	2,6
	4. Төв	5,0	4. Дорноговь	2,7
	5. Ховд	4,6	5. Булган	2,7
2024	1. Улаанбаатар	23,7	1. Говьсүмбэр	0,4
	2. Өвөрхангай	5,3	2. Өмнөговь	1,9
	3. Хөвсгэл	5,3	3. Дундговь	2,6
	4. Төв	5,1	4. Булган	2,6
	5. Ховд	4,7	5. Дорноговь	2,7

Үүнд: баруун бүсэд Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, зүүн бүсэд Дорнод, Хэнтий, Сүхбаатар, өмнөд буюу говийн бүсэд Өмнөговь, Дорноговь, Дундговь, Говьсүмбэр, Баянхонгор, төвийн бүсэд Төв, Сэлэнгэ, Хөвсгэл, Архангай, Өвөрхангай, Булган аймгуудыг тус тус оруулсан бөгөөд хот болон хот маягийн бүс нутагт Дархан-Уул, Орхон аймгууд, Улаанбаатар хотыг оруулав. Хүн амын байршлын онцлогоос шалтгаалан хүн амын өсөлтийн түвшин эдгээр бүс нутагт ихээхэн ялгаатай байна. Тухайлбал, 1999 оны байдлаар баруун болон төвийн бүс, хот, хот

маягийн бүсэд Монгол улсын нийт хүн амын 79 орчим хувь нь амьдрах төлөвтэй байгаа бөгөөд 2004 онд нийт хүн амын 78,8%, 2009 онд 78,6%, 2014 онд 78,5%, 2019 онд 78,3%, 2024 он гэхэд 78,3% нь тус бүс нутагт төвлөрөх хандлагатай байна. Эндээс харахад төдийлэн өөрчлөлтгүй юм шиг байгаа мөртлөө бүс нутаг тус бүрээр аваад үзэхэд нэлээд ялгаатай дур зураг гарч ирж байгаа юм. Ирэх зууны эхний 20 жилийн байдлаар ялангуяа төвийн бүс нутагт хүн амын ихэнх нь төвлөрөх ба харин хот маягийн бүс нутагт оршин суугчид багасах төлөвтэй байна. Энэ нь байгаль цаг уурын нөхцөл байдал, орчин ахуй, хөдөө нутгийн хөгжлийн түвшинтэй салшгүй холбоотой зүйл боловч хүн амын төрөлтийн түвшин хөдөөд өндөр байдаг нь хүн амын өсөлт их байх нөхцөлийг бүрдүүлж өгч байгаа юм. Өмнөд болон зүүн бүс нутгийн хүн амын өсөлтөд онцын өөрчлөлт байхгүй байх төлөвтэй.

Манай орны хувьд хүн амын жилийн дундаж өсөлтийн хурд 1950-аад оныг хүртэл 1 хувьд ч хүрэхгүй байсан бөгөөд 1950-аад оноос хойши хийгээм эдийн засгийн хөгжлийн түвшин тухайлбал, аж үйлдвэржилт, хотжилт, эрүүлийг хамгаалах системийн хөгжил, мөн тэр үеэс эхлэн хүн амын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хүн амын тогтвортой өсөлтийг хангах нөхцөл бүрэлдсэнээр 1950–1960 оны хооронд хүн ам жилд дунджаар 2.34 хувиар, 1970–1980 онуудад 3.32 хувиар өсөн хамгийн оргил үедээ хүрсэн бөгөөд харин 1993–1996 он гэхэд 1.47 хувь болон буурчээ.

Хэтийн тооцооны үеүдээр хүн амын өсөлтийн жилийн дундаж хурдыг авч үзэхэд 1989–1994 онд 2.7 байснаа хэтийн тооцооны эцэс гэхэд 1.3 болж буурах хандлагатай байна. Хүн амын өсөлтийн хурдны бууралт нь төрөлтийн түвшний бууралттай холбоотойгоор тайлбарлагдах ба 1990–ээд оны эхэн үеийн төрөлтийн бууралтын огцом өөрчлөлт (учир нь Монгол улсын хувьд 1993 онд урьд өмнөхтэй харьцуулахад харьцангуй цөөхөн хүүхэд төрсөн) нь ирэх зууны эхний хагасын төрөлтийн түвшнийг өөрчлөх бөгөөд яг энэ өөрчлөлтийн нөлөөлөл 2009–2014 оны үеэс ажиглагдах нь дамжигүй. 1989–1994 оны байдлаар Дорнговь 2.4%, Завхан 2.5%, Өмнөговь 2.2%, Улаанбаатар 2.6%-ийн өсөлтийн хурдтай байгаа нь улсын дунджаас (2.7%) бага байна. 1994–1999 онд Дорнговь 2.4%, Өмнөговь 2.4%, Улаанбаатар 2.5%, Говьсүмбэр 2.1% өсөлтийн хурдтай байгаа нь улсын дунджаас бага байгаа бөгөөд харин дараагийн 5 жилд нь зөвхөн хот, хот маягийн бүс нутгийн хүн амын өсөлтийн хурд улсын дунджаас ялимгүй бага байх төлөвтэй байна. Бүх аймаг хотын хувьд хүн амын өсөлт хурд 2004–2009 он хүртэл нэмэгдэх төлөвтэй байгаа ч 2010 оноос аажим бууралттай байх болно. Сэлэнгэ, Төв, Увс, Хэнтий, Улаанбаатар, Говьсүмбэр зэрэг аймаг хотуудад хүн амын өсөлтийн хурд хэтийн тооцооны бүх үеийн турш буурах хандлагатай байхад харин бусад аймгийн тухайд өсөөд буурах хандлага ажиглагдаж байна.

Хүн амын тооны жилийн дундаж өсөлтөөс хамааруулан хүн амын нөхөн үйлдвэрлэлийн байдлыг тодорхойлдог. Манай улсын хүн амын нөхөн үйлдвэрлэлийн байдал 1950-аад оноос өмнө "удааширсан" үед байсан бол сүүлийн 40-өөд жилийн хугацаанд хүн амын нөхөн үйлдвэрлэлээрээ "хэт хурдан" бүлэгт багтдаг болсон ба 1990–ээд оны төрөлтийн түвшний бууралтын үр дүнд хүн амын өсөлтийн хурд удааширч

нөхөн үйлдвэрлэл "хурдан" гэсэн бүлэгт багахаа болжээ. Хүснэгт 5-д хүн амын өсөлтийн хурд болон нөхөн үйлдвэрлэлийн байдлыг үзүүлэв. Эндээс харахад 21-р зуунд хүн амын нөхөн үйлдвэрлэлээрээ "хурдан" бүлэгт багахаа болж ирээдүйн чиг хандлагаараа хүн амын нөхөн үржихүйн энгийн байдалд хүрэхэд нэг их холгүй байгаа нь харагдаж байна.

Хүснэгт 5. Хүн амын өсөлтийн хурд, Монгол, 1918–2024 он		
Хугацааны завсралт	Хүн амын өсөлтийн хурд (%)	Хүн амын нөхөн үржихүйн байдал
1918–1935	0,82	Удааширсан ўе
1935–1940	0,01	
1940–1945	0,55	
1950–1955	1,80	Нэн хурдан ўе
1955–1960	2,65	
1960–1965	2,97	
1965–1970	2,87	
1970–1975	3,15	Хэт хурдан ўе
1975–1980	3,02	
1980–1985	2,62	
1985–1990	2,60	
1990–1993	1,90	Нэн хурдан ўе
1993–1996	1,47	Хурдан ўе
1989–1994	2,70	
1994–1999	2,60	Хэт хурдан ўе
1999–2004	2,50	
2004–2009	2,30	
2009–2014	2,00	Нэн хурдан ўе
2014–2019	1,70	
2019–2024	1,30	Хурдан ўе

— Бүртгэгдсэн
— Тооцсон

Манай улсын хувьд хүн амын өсөлтөд ердийн өсөлт зонхилох үүргийг гүйцэтгэдэг. 1989–1994 онуудын хооронд ердийн өсөлт хэмжээ 61.9 мянга буюу 1000 хүн тутамд 36.2 хүн нэмэгддэг байсан бол хэтийн тооцооны дунд ўед буюу 2004–2009 онуудын хооронд 79.7 мянгад хүрч хамгийн өндөр түвшиндээ хүрэх бөгөөд энэ ўед дунджаар 1000 хүн тутамд 30.7 хүн нэмэгдэх ажээ. Хүн амын төрөлтийн түвшин буурч байгаа нас барагтын тоо хэмжээ нэмэгдэж байгаатай холбоотойгоор ердийн өсөлт хэтийн тооцооны сүүл гэхэд нэлээд буурах төлөвтэй байна. Магадгүй энэ ўе

Иншээдээ дэд хувьд хамгийн түвшний тооцооны сүүл гэхэд нэлээд буурах төлөвтэй байна.

Эс хүн амын өсөлт зөвхөн ердийн өсөлтөөр бус механик өсөлтөөр зохицуулагддаг болж ч болох юм.


Хүн амын шилжилтийн үе шат бүхэнд хүн амын нас, хүйсийн бүтэц янз бүр байна. Зураг 1, Зураг 2, Зураг 3-аас 1997 оны үеэс эхлээд 2024 оныг хүртэлх хугацаанд нас, хүйсийн бүтэц болон хүн амын тоо хэмжээ хэрхэн өөрчлөгдж байгааг харж болно.

Зураг 1: Хүн амын суварга, Монгол, 1997




Эндээс харахад улс орны хөгжлийн өөр өөр үед насын бүлэг бүрт байх хүн амын тоо нь төрөлт, нас барагтын харилцан адилгүй түвшнээс шалтгаалан өөрчлөгдж байна. 15–49 насын бүлэгт байх насанд хүрэгчдийн хувийн жин төдийлэн өөрчлөгдхгүй байхад 0–14 насын хүүхдийн хувийн жин 50%–29.6% хүртэл, мөн 50 наслас дээшхи хөгшин хүмүүсийн хувийн жин 4.8%–15.3% болтол нэлээд өөрчлөгдсөн байгаа юм. Насын бүтцэд гарч буй эдгээр өөрчлөлтүүд нь тухайн улс оронд нийгэм хангамж, боловсрол, эрүүл мэндийн салбарт оруулах хөрөнгө оруулалт асуудалд ихээхэн нөлөөг узүүлнэ.

Зураг 2: Хүн амын суварга, Монгол, 1999



Монголын хүн амын насны бүтэц нийгмийн үйлчилгээний хувьд харьцангуй зохистой байх нь харагдаж байгаа юм. Бололвсролын янз бүрийн түвшинд шинээр элсэх хүмүүсийн тоо удаавтар болоч буурч байна. Эрүүл мэндийн үйлчилгээг өргөтгөн сайжруулахад шаардагдах нөөцийн хэмжээ одоогийнхтой харьцуулахад нэг их биш байх бололтой. Гэхдээ энд тэмдэглэж хэлэхэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хангамжийн үйлчилгээг шаардсан хүн амын абсолют тоо өссөн хэвээр байх болно. Хүн амын хувьд анхаарууштай нэг хамгийн гол асуудал бол эрчимтэй өсч буй хөдөлмөрийн насны хүн ам юм. 1989–2024 онуудын хооронд 1969–1989 онуудынхтай харьцуулахад хөдөлмөрийн насны хүн ам зөвхөн абсолют тоогоороо ч бус нийт хүн амд зэлэх хувийн жин, жилийн дундаж өсөлтийн хурдаараа ч өндөр байх нь ажиглагдаж байна.



1969–1989 онуудын хооронд хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 49.6–54.1%–ийг эзэлдэг байсан бол энэ үзүүлэлт 1999–2024 онуудын хооронд 55.2–66.0% болж хүн амын ихэнх хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзлэх төлөвтэй байна. Хөдөлмөрийн насны энэ олон тооны хүн амыг ажлын байраар хангах явдал ирэх зуунд шийдвэрлүүштэй асуудлын нэг болж байгаа бөгөөд эдгээр өсөлт дээр одоо ажилгүй байгаа хүмүүсийн асуудлыг нэмэхэд бүр ч хүндрэлтэй байх нь зайлшгүй.

Нийт хүн амд эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 1956 онд 49.7:50.3, 1994 онд 49.6:50.4, 1997 онд 49.6:50.4 байсан бол хэтийн тооцооны эхний үе буюу 1999 онд 50.4:49.6 болж хэтийн тооцооны эцсийн үе гэхэд 50.6:49.4 болж ялимгүй буурах хандлагатай ч харьцангуй тогтвортой түвшинд байна гэж хэлж болох юм. Иймд ирэх зуунд хүйсийн харьцаа алдагдахад хүргэх гадна дотны хүчин зүйлсийн нөлөөлөл байхгүй байх төлөвтэй байна. Аймаг, хотын хувьд ч онц гойд өөрчлөлтгүй байх төлөвтэй.

Хүйсийн харьцаа 1989 оны тооллогоор 99.7, 1997 онд 98.6 байсан бол 1999 оноос ялимгүй нэмэгдэж 101.5, 2009 онд 102.4, 2024 он гэхэд 102.4

болов төлөвтэй. Насны бүлгийн хувьд авч үзэхэд 15 ба түүнээс доош насныхны хувьд харьцангуй тогтвортой 104.1–104.2 орчимд байхад 15–49 насны хүн амын тухайд 100.9–103.6 болж нэмэгдэх шинжтэй байна. Харин 50–59 насныхны хувьд энэ үзүүлэлт нэлээд өөрчлөлттэй байх ба 103.1–98.9 болж буурах хандлагатай байгаа юм. Аймаг, хотын байдлаар авч үзэхэд Баянхонгор, Булган, Говь-Алтай, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Ховд, Хөвсгөл зэрэг аймгуудад 50 ба түүнээс дээш насны хүн амын хүйсийн харьцаа дээрх зүй тогтлоос өөр хэтийн тооцооны үе бүрт бага зэргийн өсөлттэй байхад харин бусад аймаг, хотуудад үүний эсрэг дээрх зүй тогтолтой ижил байгаа юм. Баян-Өлгий, Сүхбаатар, Сэлэнгэ, Төв, Увс, Ховд, Хэнтий, Орхон, Говьсүмбэр аймгуудад хүйсийн харьцаа улсын дунджаас 1.5–3.5-аар илүү байна.

Хүн амын нас, хүйсийн бүтцийг илэрхийлэгч үзүүлэлтийн нэг нь хүн амын насны голч юм. Энэ нь хүн амыг яг таллан хуваадаг нас бөгөөд хэрэв тухайн улс оронд төрөлтийн түвшин өндөр бол насны голч бага байх ба төрөлтийн түвшний бууралттай холбоотойгоор өсдөг үзүүлэлт юм.

Манай орны хувьд 1956 онд насны голч 26.6 байсан 1989 онд 18.7 болсон нь төрөлтийн түвшин өндөр байсантай холбоотой бөгөөд 1990-ээд оны эхэн үеийн төрөлтийн түвшний бууралттай холбоотойгоор 1996 он гэхэд 20.9 болсноор хүн амын тал хувийг 20 ба түүнээс доош насны хүүхэд, залуучууд эзлэх болжээ. Хүснэгт 6-д аймаг, хотын байдлаар хүн амын насны голчийн талаарх мэдээллийг үзүүлэв.

Хүснэгт 6. Хүн амын насны голч, аймаг, хотоор, Монгол, 1989–2024 он

Аймаг, хот	1989	1994	1999	2004	2009	2014	2024
Бүгд	18,8	19,2	19,7	20,1	20,9	22,0	25,4
Архангай	18,0	18,1	18,2	18,2	18,6	19,5	23,4
Баян-Өлгий	16,2	16,2	16,1	16,1	16,2	17,1	22,4
Баянхонгор	17,3	17,3	17,3	17,5	18,1	18,9	22,7
Булган	18,7	19,2	20,0	20,4	21,2	22,1	25,2
Говь-Алтай	17,2	18,1	18,7	19,1	19,7	20,6	24,4
Дорнговь	18,9	18,8	19,3	20,0	21,2	22,3	25,3
Дорнод	17,9	17,9	18,1	18,6	19,2	20,1	23,9
Дундговь	17,6	18,0	18,3	18,8	19,4	20,2	23,8
Завхан	17,7	18,6	19,5	20,2	20,8	21,6	24,9
Өвөрхангай	17,8	17,7	17,9	18,1	18,6	19,5	23,0
Өмнөговь	18,3	18,4	18,7	19,5	20,6	21,5	24,6
Сүхбаатар	17,6	17,7	18,3	19,1	19,6	20,2	23,6
Сэлэнгэ	17,8	18,4	18,6	18,9	19,7	20,9	24,6
Төв	18,1	18,4	18,6	18,8	19,4	20,3	24,0
Увс	17,2	17,6	17,9	18,2	18,7	19,7	23,6
Ховд	16,9	16,5	16,2	16,3	16,9	18,1	22,1
Хөвсгөл	18,5	18,5	18,8	18,9	19,6	20,6	24,1
Хэнтий	18,9	18,6	19,0	19,3	19,8	20,9	24,5
Дархан-Уул	18,9	20,5	21,0	21,5	22,0	24,0	28,1
Улаанбаатар	20,6	21,7	22,4	22,9	23,6	24,7	28,0
Орхон	20,7	19,7	20,4	21,5	22,5	23,6	26,8
Говьсүмбэр		23,9	25,0	26,3	27,9	29,0	28,4

Хүснэгтээс харахад Баян-Өлгий 16.2–22.4, Ховд 16.9–22.1 наасны голчтой байгаа нь бусад аймаг хоттой харьцуулахад харьцангуй бага байгаа бөгөөд энэ нь тэдгээр аймгийн төрөлтийн өндөр түвшинтэй холбоотойгоор тайлбарлагдана. Харин бусад аймгуудын хувьд улсын дундажтай ойролцоо байгаа ба Дархан-Уул, Орхон, Улаанбаатар, Говьсүмбэр зэрэг аймгуудад наасны голч нэлээд өндөр байна. Энэ нь эдгээр аймгууд нь хот маягийн суурьшил, соёл иргэншилтэй, нийгэм эдийн засгийн хөгжлийн түвшин бусад аймгийг бодоход нэлээд өндөр, зам тээврийн харилцаа өргөн нэвтэрсэн, дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдсэний зэрэгцээ төрөлтийн түвшин бага байдагтай холбоотой юм.

Насны голчийг хүйсийн ялгавартай байдлаар авч үзэхэд 1989–2024 онуудын хооронд эрэгтэйчүүдийн хувьд 18.5–25.1, эмэгтэйчүүдийн хувьд 19.0–25.7 болж нэмэгдэх төлөвтэй байна. Аймаг, хотын түвшинд хүн амын наасны голчийг хүйсийн ялгавартай байдлаар Говь-Алтай аймгийн хувьд хэтийн тооцооны бүх үеүдэд эрэгтэй хүн амын наасны голч эмэгтэйчүүдийнхээс 9.5–10.5-аар бага байгаа ба зөвхөн 1989 оны байдлаар Хөвсгөл, Ховд, Сүхбаатар, Завхан зэрэг аймгуудийн эрэгтэйчүүдийн наасны голч эмэгтэйчүүдийнхээсээ даруй 10-аар зөрүүтэй байгаа юм. Харин бусад аймгийн тухайд хоёр хүйсийн хооронд төдийлэн зөрүү ажиглагдахгүй байна.

Хүснэгт 7. Хүн ам зүйн ачаалал, аймаг, хотоор, Монгол, 1999–2024

Аймаг, хот	1999	2004	2009	2014	2019	2024
Бүгд	78,8	75,3	70,6	64,0	57,3	50,8
Архангай	90,3	89,1	85,0	76,0	65,4	54,5
Баян-Өлгий	102,3	101,2	100,3	90,3	67,3	51,5
Баянхонгор	95,0	92,3	87,2	79,7	68,9	56,5
Булган	79,0	73,3	71,6	66,4	58,2	49,9
Говь-Алтай	83,5	81,1	77,8	70,3	60,4	51,2
Дорноговь	80,4	72,5	69,5	64,6	56,9	50,9
Дорнод	88,9	83,2	78,7	72,3	63,0	53,3
Дундговь	89,6	83,3	79,2	72,1	62,9	53,0
Завхан	77,7	74,4	73,7	67,9	58,5	49,1
Өвөрхангай	91,7	87,8	83,0	76,5	67,3	56,2
Өмнөговь	87,2	76,8	73,6	68,1	60,6	51,2
Сүхбаатар	87,1	79,8	78,8	74,3	64,7	53,8
Сэлэнгэ	84,4	80,9	75,9	67,7	59,2	51,3
Төв	86,9	84,3	79,1	71,6	62,3	52,6
Увс	89,1	87,4	83,2	74,9	64,5	53,8
Ховд	103,5	101,6	94,7	82,9	69,7	56,9
Хөвсгөл	87,0	82,5	76,8	70,4	62,0	53,1
Хэнтий	84,0	81,8	76,3	68,9	61,1	53,4
Дархан-Уул	70,6	66,8	60,0	53,5	49,7	45,6
Улаанбаатар	67,0	64,9	59,6	53,5	49,3	46,8
Орхон	68,6	63,7	58,2	55,5	54,8	51,8
Говьсүмбэр	45,3	46,6	62,3	55,5	49,0	45,4

Улсын хэмжээгээр болон нийт аймаг, хотын хувьд хэтийн тооцооны бүх үеүдэд насны голч нэмэгдэх хандлагатай байгаа ба энэ нь тухайн үеийн төрөлтийн бууралттай холбоотойгоор тайлбарлагдах ёстой. Ямар ч л байсан ирэх зууны эхний хагаст Монгол улсын хүн амын тал хувь нь 25-аас доош насны хүүхэд, залуучууд эзлэх төлөвтэй байгаа бөгөөд мөн л хүн амын насны бүтцээрээ залуу улсын тоонд орсон хэвээр байх бололтой.

Манай улсын хувьд хүн ам зүйн ачаалал 1956 онд 57.8, 1969 онд 101.8, 1989 онд 84.9, 1994 онд 76.5 байсан бөгөөд 1960–1970-аад оны үед нэлээд өндөр байсан бөгөөд энэ нь тэр үеийн өндөр төрөлтийн түвшний үр дүн юм. Харин 1980-аад оны дунд үеэс төрөлтийн түвшин буурсантай холбоотойгоор хүн ам зүйн ачаалал мөн буурчээ. Хэтийн байдлыг нь тооцож үзэхэд хүн ам зүйн ачаалал 1999–2024 онуудын хооронд 78.8–50.8 болтлоо буурах бололтой. Хүүхдийн ачаалал төрөлт буурч байгаатай уялдаж 72.5–44.1 болж 60 орчим хувиар буурч байхад хөгшчүүдийн ачаалал 6.3–6.7 болон нэмэгдэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл ирэх зууны эхэн гэхэд 15–64 насны 100 хүн 44 хүүхэд, 7 хөгшин насны хүн амыг тэжээнэ гэсэн үг юм. Хүн ам зүйн ачаалал аймаг, хотын хувьд хэтийн тооцооны бүх үеийн турш буурч байгаа юм. Баян-Өлгий, Ховд аймгуудад 102.3–103.5 байгаа нь улсын дунджаас ч өндөр байгаа ба энэ нь тухайн аймгуудын төрөлт бусдыг бодоход өндөр байгаатай холбоотой. Улаанбаатар, Дархан-Уул, Орхон, Говьсүмбэр зэрэг хот суурин газруудын хүн ам зүйн ачаалал 1989–2024 онуудын хооронд улсын дунджаас байнга бага байх төлөвтэй байна. Энэ байдал нь мөн л тухайн газрын төрөлтийн түвшин бага гэж дээр өгүүлсэнтэй ижилхнээр тайлбарлаж болох юм.

Ашигласан материал:

1. "Монгол улсын хүн ам", УСГ, 1994.
2. "Монгол улсын эмэгтэйчүүд, хүүхэд", УСГ, 1995.
3. "Монгол улсын нийгэм эдийн засаг 1996 онд", УСГ, 1997.
4. "Монгол улс 21-р зуунд", М. Энхсайхан нар, 1997.
5. "PEOPLE", Үндэсний болон бүс нутгийн хүн амын хэтийн тооцоог хийх хэрэглээний багц программ, 1995.
6. Henry S. Shryock, Jacob S. Siegel and Associates, "The Methods and Materials of Demography"